

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ**

2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

ЕРӨНХИЙ ЗААЛТ

Гэрээний нэр	Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх
Гэрээний дугаар:	41
Захиалагч байгууллага	Сангийн яам
Захиалагч байгууллагын төлөөлөх эрх бүхий нэгж	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар
Гүйцэтгэгч байгууллага	Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн
Гэрээний эхэлсэн огноо:	2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр
Гэрээ дүгнэсэн огноо:	2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

1. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Гэрээний тусгай нөхцөл	Биелэлт	Хувь
2.1.1.Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулан батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	1. Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн асуудлаар ирсэн мэдээлэл хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар СЯ-д мэдээлэх - Төрийн өмчит аж ахуйн нэгжийн ерөнхий нягтлан бодогчдын ёс зүйн байдлын судалгааны асуулт боловсруулж Сангийн яамтай хамтран гүүгл формоор 304 нягтлан бодогчоос судалгаа авч боловсруулаад тайланг Сангийн яаманд 2022 оны 12 дугаар сард 1/26 тоот албан бичгээр хүргүүлсэн болно. Судалгаагаар нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн мэдлэгийг тодорхойлох, нягтлан бодогчид өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх идэвх санаачилгын байдал, нягтлан бодогчид мэргэжлийн алдаа дутагдал гаргаж байгаа байдалд үнэлгээ өгсөн болно.	90%
	2. Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс дүрмийн талаар төгсөгч оюутнуудад мэдээлэл хийх - Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэмд Олон улсын нягтлан бодох бүртгэлийн хорооноос баталсан Боловсролын олон улсын стандарт 7-д заасны дагуу 3 жилд 60 цагийн баталгаажуулах сургалтад заавал хамрагдсан байх шаардлагыг тусгасан өөрчлөлт хийж 2022 оны 10 сарын 21-ний Удирдах зөвлөлөөр батлуулав.	80%

2.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөх програм хангамж нь СТОУС, УСНББОУС болон Монгол Улсын холбогдох заавар журамд нийцсэн эсэх талаарх мэдээллээр хангах.	3.Аж ахуйн нэгжид зориулж шинээр хөгжүүлсэн НББ-ийн программд үнэлгээ өгөх ажлыг хийх 1. Хугацаа дууссан дараах компанийн НББ-ийн программыг шалгаж зөвшөөрлийг сунгуулсан. Үүнд. • Ординат ХХК-ийн Unicus 2.1 • Интерактив ХХК Veritech ERP 6.1 • Интерсолюшнс ХХК Динамик 365 Бизнес Централ • Инфосистемс ХХК Макс/Macs/XE3 2. Шинээр зөвшөөрөл авах дараах компаниудын программд дүгнэлт гаргав. Үүнд: • Коормайнд ХХК Coremind Odoo ERP 13 • Артлаб ХХК Artlab v3 • Юнитакс ТИН ХХК Tax Acc1.0 • Астерикс технологис ХХК ODERP 14.0 3.Зөвлөмжийн хэрэгжилт дутуу учраас зөвшөөрөл нь сунгагдаагүй программууд: • Прософт ХХК Prosoft Account 4.0 • Эн Эй Эм Эй ХХК Эрхэт • Астерикс технологис ХХК ODERP 10.0 • Вансифорус ХХК 1c Enterprise 4.НББ-ийн программ зохиогч компаниудаас боловсруулж Төсөвт байгууллагуудад шинээр суурилуулах программуудад үнэлгээ өгөх 1. Хугацаа дууссан төсөвт байгууллагын дараах компанийн НББ-ийн программыг шалгаж зөвшөөрлийг сунгуулсан. Үүнд. • Ординат ХХК Unicus 1.1 • Си Ти Эс ХХК CTSsystem 6.0.1 • ШУТИС U-Finance 3.0 2.Зөвлөмжийн хэрэгжилт дутуу учраас зөвшөөрөл нь сунгагдаагүй төсөвт байгууллагын программууд: • Санхүүгийн тооцоолох ХХК Acolous 4.0 5.НББ-ийн программ зохиогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх: Си Ти Эс ХХК, Интерсолюшнс ХХК, Инфосистемс ХХК, ШУТИС-ийн программ зохиогчдод ганцаарчилсан зөвлөгөө өгсөн болно.	100% 100% 90%
2.1.3. Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжид хяналт тавих;	6.НББ-ийн программ зохиогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх: “Нягтлан бодох бүртгэлийн программ хөгжүүлэгчдийн семинар”-ыг 2022 оны 5 дүгээр сарын 06-нд зохион байгуулсан бөгөөд түүнд НББ-ийн программ хөгжүүлэгч 30 компанийн төлөөлөл 60 гаруй программ зохиогч оролцов	100%

	Семинарыг Сангийн яам, ММНБИ-тэй хамтран зохион байгуулав. Семинарт МНББХ, Гааль, татварын санхүүгийн мэдээлэл технологийн төв УҮГ, ТМЗ нийгэмлэг, болон багш, судлаачид дараах илтгэлийг хэлэлцүүлэв. Нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлагын хэрэгжилтийн байдал, Санхүү, татварын цахимжуулалт, цаашдын шинэчлэлтийн тухай, СТОУС-т нийцэх тайлагнал ба татварын бүртгэлийн программ хангамжийг хөгжүүлэх нь, ERP системийн шаардлага, хэрэглээний байдал ERP системийн боломжийн үнэлгээ зэрэг болно. Семинарт оролцогчид семинарын ач холбогдлыг өндөр үнэлж, НББ-ийн программын хөгжүүлэлтэд анхаарах асуудал, ойрын үеийн чиг хандлагыг тодорхойлсон, чухал мэдээлэл авсанд баяртай байгааг илэрхийлж байлаа. 7.Хүрээлэнгийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг газар дээр нь үзэж танилцах Ординат ХХК-ийн Unicus 2.1, Интерактив ХХК Veritech ERP 6.1, Интерсолюшнс ХХК Динамик 365 Бизнес Централ, Инфосистемс ХХК Макс/Мас/ХЕЗ, Прософт ХХК Prosoft Account 4.0, Эн Эй Эм Эй ХХК Эрхэт, Астерикс технологис ХХК ODERP 10.0, Вансифорус ХХК 1c Enterprise, Ординат ХХК Unicus 1.1, Си Ти Эс ХХК CTSsystem 6.0.1, ШУТИС U-Finance 3.0, Санхүүгийн тооцоолох ХХК Acolous 4.0 гэх мэт 12 компанид өмнөх өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг очиж танилцаж зөвлөгөө өгсөн.	90%
2.1.4.Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн хэрэглээний чиглэлээр зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх.	8.НББ-ийн программд тавигдах нийтлэг шаардлага /стандарт/ баримт бичгийн төсөл боловсруулж СЯ-д шилжүүлэх Дараах бичиг баримтын төслийг боловсруулж 2022 оны 05 сарын 28-нд Сангийн яам, ММНБИ-д явуулаад байна . Үүнд: 1.Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах СТОУС-ын шаардлага 2.Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах УСНББОУС-ын шаардлага	80%
2.1.5. Ажил эрхэлж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах	9.Ажил эрхэлж байгаа нягтлан бодогчдыг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх. Мэдээллийн сан байгуулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. 2022 онд 320 нягтлан бодогчийн мэдээллийн санд нэмж бүртгэсэн болно.	80%

	10.Ажил эрхэлж байгаа нягтлан бодогчдын мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. "Мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг зохион байгуулах журам"-ын төсөл боловсруулаад 2022 оны 10 сарын 21-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар батлуулсан. Нягтлан бодогчдын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хэрэгжүүлэх талаар хийсэн судалгаанд тулгуурлан нягтлан бодох бүртгэлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл болон бусад холбогдох багц бичиг баримтыг боловсруулаад байна. Энэ төслийн талаар санал авах болон хэлэлцүүлэгт бэлтгэж байна.	70%
--	--	-----

Нийт нийлбэр дүнгээр гэрээний үүргийн биелэлт 88 хувь гэж хоёр тал харилцан тохиролцов.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

САНГИЙН САЙД:

Б.ЖАВХЛАН



САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА:
Б.БОЛОРМАА

Болормаа

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛЫН НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Л.ДОНДОГ

